

Жамбын ДАШДОНДОГ

# ӨРГӨӨ





## ҮҮДНИЙ ҮГ

Сайн бүхнээ  
аваад орогтун!  
Саар бүхнээ  
гадаа орхигтун!

*Дэлхий гэрт анх  
та цагаан цайлган  
сэтгэлээс ондоо юу ч  
үгүй ирсэн бус уу?*



# РОБОТ

РОБОТ ЧАДАМГАЙ  
ОЙТОЙ УХААНТАЙ  
ОЛОН ХҮНИЙ АЖЛЫГ  
ОРЛОН ХИЙЖ ЧАДНА  
ТӨВӨГҮЙ БОДНО  
ЧӨЛӨӨТЭЙ ЯРИНА  
ТЭРЭЭР  
ТЭГЭЭД

ГАН ТӨМӨР ГАГНАЖ ЧАДНА  
ГАЛ ДУНД АЖИЛЛАЖ ЧАДНА  
ДАЛАЙН ГҮНД Ч НЭВТЭРНЭ  
САНСРЫН УУДАМД Ч НИСНЭ  
ХҮҮХДҮҮДЭД ЭРДЭМ ЗААНА  
ХҮНД АЧААГ ӨРГӨН ТЭЭНЭ  
ХОВОР ЭРДЭНЭ ОЛЖ НЭЭНЭ  
ХОНЬ ХЯРГАЖ ҮНЭЭ СААНА  
РОБОТ ТУСЛАГЧ ХЭН ХҮНД  
ОНЦГОЙ ХЭРЭГТЭЙ БОЛЖЭЭ  
ШҮЛЭГ ЗОХИОДОГ ТУСЛАГЧ  
НАДАД ХЭРЭГТЭЙ БАЙНА Л

УРАН ШҮЛЭГ  
ЗОХИОЖӨГӨХ  
УХААНТ НЭГ  
РОБОТ ХИЙВ  
ОНЬСОН ХҮН  
РОБОТ МИНЬ  
ОЛОН ШҮЛЭГ  
БИЧЛЭЭ ДЭЭ  
ХЭЛБЭР ДҮРС НЬ  
РОБОТ ЧИННИЙХ Ч  
ХЭЛЭХ САНАА НЬ  
ГАГЦХҮҮ МИНИЙХ



# ӨРГӨӨ

Ш  
И  
Н  
Э

ШҮЛГИЙН

ШИЖИР АЛТАН

ТООНОО БИ ӨРГӨЖ

ҮСГИЙН ХАНАА ДЭЛГЭЖ

УТГАТ ҮГИЙН УНИА ӨЛГӨӨД

УЯНГАТ ШҮЛГИЙН ГЭРЭЭ БАРИАД

ЭХ ДЭЛХИЙН БҮХ ХҮҮХДИЙГ УРИВ АА

ЭГШИГТ НАЙРАГТ ДУРТАЙ БҮХЭН ИРЭЭРЭЙ

ГАНЦ Л ҮСЭГ ХӨНДӨӨЛ ГАЖИЖ МЭДЭМ ХИЙЦТЭЙ

ГАЙХАМ ШИДЭТ ЯРУУ НАЙРГИЙН БАТ ЦАГААН ӨРГӨӨ

ШҮЛГИЙН МӨНГӨН ЦАЙ

ГИЙЧИНДЭЭ БАРИАТАЙ

АЯЫН ЦЭНХЭР ХАДГАА

АЙЛЧИНДАА ӨРГӨӨТЭЙ

НАЙРГААРАА ИСГЭСЭН

АЙРГААР ДАЙЛААСТАЙ

ХОТЛЫГ НАЙРГААРАА

БАЯСГАХ ГЭЖ УРЛАСАН ӨРГӨӨ

ХОЙЧ ҮЕДЭЭ ҮЛДЭЭЖ ӨГӨХ ШҮЛГИЙН ЦАГААН ӨРГӨӨ

МОРИН ХУУРАА ТАТАЖ

МОНГОЛ ДУУ СОНСГОЕ

ЗОХИОСОН ДУУГ МИНЬ

ЗОЧИД МИНЬ ТҮРЦГЭЭ

НАЙРГИЙН ГЭРТ МИНЬ

НАИЗ НӨХӨД БОЛЦОО

ХАМГААГАХ

ХӨНДӨӨЛ

УРИВ АА





# ТРАКТОР

ТР	ТРАКТОРЫН ДУУ
ТР	ТАЛД НУРГЭЛЭВ
ТР	ТРАКТОРЧИН ЭР
ТР	ЯАРЧ ТҮРГЭЛЭВ
ТРР ТРР ТРР ТРР ТРР	ГАНЦХАН ҮРИЙГ
ТРА ТРА ТРА ТРА ТРА	ЗУУ БОЛГОХООР
ТРАК ТРАК ТРАК ТРАК	ГАЗАР ТЭДНИЙГ
ТОР ТОР ТОР ТОР ТОР	ДУУДАН БАЙГАА
ТРАКТОРЫН МОТОР	ГАВШГАЙ АЖЛЫН
ТАРР ТАРР ХИЙН АСАВ	ГАРАА ЭХЭЛЛЭЭ

ХАВРЫН ТАЛБАЙД ЗУТГЭСНИЙ ҮРИЙГ  
НАМРЫН ТАЛБАРТ ТАРИАГААР БИЧНЭ  
ХУЧИТ ТРАКТОР ХҮРЖИГНЭН ХӨДЛӨВ  
ХҮРЭЛ ГИНЖ НЬ ХАРЖИГНАН ХӨДЛӨВ

## МАЙХАН

ХӨХ ТЭНГЭРТ ШУВУУД ЗЭЛЛЭН  
БУЦАЖ ОДОХ НЬ УЙТАЙ Ч ГЭСЭН  
ХӨРСТ ГАЗАРТ МАЙХНУУД АЛАГЛАН  
БУУЖ ИРЭХ НЬ СЭТГЭЛД НЭН САЙХАН  
ЦЭЦЭГ ХАГДРАВЧ АМТАТ ЖИМС БӨНЖИЙЖ  
ЦЭНГЭЛТ ЗУН ӨНГӨРӨВЧ АЛТАН ЦАГ ГАРЧ  
НАВЧ НОГООНЫ СӨЛТЭЙД ХАДСАН ӨВСНИЙ ИШ  
НАМРЫН АЙРАГ ШИГ ХАМАР ЦОРГИН СЭНГЭНЭНЭ  
ДАРАЙСАН ЦАГААН ХЯРУУНААС ДАЙЖИН ОДОХ МЭТ  
ДАНГИЙН ДААВУУ МАЙХНУУД УУЛС ДАВАН НҮҮСЭН Ч  
ОРОНД НЬ ҮЛДСЭН УРТ НОГООН НУРУУ ЮУТАЙ СҮРЛЭГ  
ОМОГТ ШУУРГАА ӨВӨЛ ДАГУУЛАН ИРЭВЧ МАЛЧИН ТАВЛАГ



## АЧААНЫ МАШИН

Хөгжөөнтэй машин  
Хөдөөгийн замаар  
Хурр хурр гэсээр  
Хүнгэнэнхэн явна  
Замын донсолгоог  
Дорхон нь гаргаж  
Шөнийн харанхуйг  
Гэрэл нь үргээнэ

Урд  
Дугуй  
Урагшаа  
Эргэн  
Буй

Идэр жолооч  
Залуурдээрээ  
Ииш тийш нь  
Мушгиж явна  
Инээн баясаж

Исгэрч явна  
Араа залгав  
Өөдөө өгсөв  
Араа салгав  
Уруу давхив  
Алсхан холд  
Яаран яарна  
Асхан дөт л  
Зам сонгоно



Тэр машин хотоос гарсан юм санж  
Тэвшиндээ тоглоом ачсан юм санж  
Хүүхэд бүхэнд хөврхөн тоглоомыг  
Хүргээд өгөх гэж яарсан юм санж  
Багачууд бүхний цайлган сэтгэлд  
Баяр түгээх гэж зорьсон юм санж

Ард  
Дугуй  
Адилхан  
Эргэн  
Буй







УУЛ

УУЛ	УУЛ
УРУУ	УРУУ
УНДУЙ	УНДУЙ
СУНДУЙ	СУНДУЙ
ЦАНАТАЙ	ЦАНАТАЙ
ЧАРГАТАЙ	ЧАРГАТАЙ
ХӨЛТЭЙХЭН	ХӨЛТЭЙХЭН
ХӨӨРТЭЙХЭН	ХӨӨРТЭЙХЭН
ХӨВҮҮД, ОХИД	ХӨВҮҮД, ОХИД
ЦАС МАНАРГАН	ЦАС МАНАРГАН
ЦАН САВСУУЛАН	ЦАН САВСУУЛАН
ХОЁР ГУРВААРАА	ХОЁР ГУРВААРАА
ГУРАВ ДӨРВӨӨРӨӨ	ГУРАВ ДӨРВӨӨРӨӨ
УРАЛДАН ЖИРЭЛЗЭН	УРАЛДАН ЖИРЭЛЗЭН
УРАГШЛАН ТЭМҮҮЛЭН	УРАГШЛАН ТЭМҮҮЛЭН
УРД ХОЙНОО ОРОЛЦОН	УРД ХОЙНОО ОРОЛЦОН
УЙТАЙ БОДЛОО ҮЛДЭЭН	УЙТАЙ БОДЛОО ҮЛДЭЭН
ДАЛЬ ЖИГУҮРЭЭ ДЭЛГЭН	ДАЛЬ ЖИГУҮРЭЭ ДЭЛГЭН
ДАЙРАН ОРОХ ШУВУУ ШИГ	ДАЙРАН ОРОХ ШУВУУ ШИГ
ЦАС САЛХИ ЯРАН СҮНХИЙЖ	ЦАС САЛХИ ЯРАН СҮНХИЙЖ
ХОС ТАЯГААН ДАЛАВЧ АДИЛ	ХОС ТАЯГААН ДАЛАВЧ АДИЛ
ХОЙШ НЬ СЭРИЙЛГЭН БӨХИЙЖ	ХОЙШ НЬ СЭРИЙЛГЭН БӨХИЙЖ
ХЭН НЭГ НЬ ХӨГЖИЛТЭЙ УНАЖ	ХЭН НЭГ НЬ ХӨГЖИЛТЭЙ УНАЖ
ТЭР ДОРОО Л БОСОН УХАС ХИЙЖ	ТЭР ДОРОО Л БОСОН УХАС ХИЙЖ
ЧАРГАН ДЭЭР ОВООРСОН ХҮҮХЭД	ЧАРГАН ДЭЭР ОВООРСОН ХҮҮХЭД
ЦАСАН ДЭЭР ХОЛБИРОН ИНЭЭЛДЭЖ	ЦАСАН ДЭЭР ХОЛБИРОН ИНЭЭЛДЭЖ
ХАЖУУГААР НЬ СУНДЛААТАЙ ЧАРГА	ХАЖУУГААР НЬ СУНДЛААТАЙ ЧАРГА
ХАР ЭРЧЭЭРЭЭ ХАРАЙН ДҮҮЛЭН ОРЖ	ХАР ЭРЧЭЭРЭЭ ХАРАЙН ДҮҮЛЭН ОРЖ
УУЛЫН ОРГИЛООС ХҮҮХДИЙН ХӨГЖӨӨН	УУЛЫН ОРГИЛООС ХҮҮХДИЙН ХӨГЖӨӨН
УУДАМ БЭЛДЭЭ ЭЗДЭЭ ДАГААД БУУЛАА	УУДАМ БЭЛДЭЭ ЭЗДЭЭ ДАГААД БУУЛАА
ЦАСТАЙ УУЛЫН ТУХАЙ ШҮЛГИЙН БЭЛДЭЭ	ЦАСТАЙ УУЛЫН ТУХАЙ ШҮЛГИЙН БЭЛДЭЭ
ЦОГТОЙ ЖААЛУУД ШИГ БИ Ч БАС БУУЛАА	ЦОГТОЙ ЖААЛУУД ШИГ БИ Ч БАС БУУЛАА

## СҮЛД МОД

МӨНХ  
НОГООН  
МӨЧИРТЭЙ  
СҮЛД МОДОО  
МӨНГӨН ОДООР  
ТЭРГҮҮЛЖ ЧИМЬЕ  
АЛТАН ГАДАС ОДЫГ  
ОРОЙ ДЭЭР НЬ ЗАЛЪЯ  
МӨНХ  
НОГООН  
МӨЧИРТЭЙ  
СҮЛД МОДОО  
ХАВРЫН ЯРГУЙ  
ӨНГИЙН СОЛОНГО  
ХӨВӨН ЦАГААН ҮҮЛ  
НАМРЫН АЛТАН ТУРҮҮ  
ЦАЛИН МӨНГӨН ЦАС МЭС  
НАРНЫ САДАН ЕСӨН ГАРИГ  
НАЙРГИЙН БАДГААРАА ЧИМЬЕ  
МӨНХ  
НОГООН  
МӨЧИРТЭЙ  
СҮЛД МОДОО  
БАЯСГАЛАНТАЙ  
ҮР ХҮҮХДИЙНХЭЭ  
ЦАРАЙД ГЭРЭЛТСЭН  
БАЯР ХӨӨРӨӨР ЧИМЬЕ  
АЙЛ БҮХЭНД ДЭЛГЭРСЭН  
АЗ ЖАРГАЛААР БАС ЧИМЬЕ  
ЭХ ДЭЛХИЙД ЭГНЭГТ МАНДАХ  
ЭНХ ТАЙВНААР ДЭЭДЛЭН ЧИМЬЕ  
ЕР БУСЫН МОДОО ЧАМД БЭЛЭГЛЭЕ  
ЕРӨӨЛТ ШИНЭ ЖИЛИЙН БАЯР ХҮРГЭЕ



АЛХ

АЛХ ХАДААС БАРЬЖ СУР  
ААВ НАДАД ИНГЭЖ ХЭЛЭВ  
ГАРТАА БИ ХАДААС БАРИВ  
ГАН АЛХААР ХАДАЖ СУРАВ  
АНХНЫТЭР Л ТОШИЛТООС  
АЙЗАМ ДУУ АЯНДАА ҮҮСЭВ

ЭНЭ АЛХ  
ГАН  
ЭРЭЛХЭГ  
БААТРЫН  
ЭРДЭНЭТ  
СЭЛМИЙГ  
ДАН ДАН  
ДАВТСАН  
ТОГ ТОГ  
ТОГШСОН  
ЭГНЭСЭН  
ХАРШИЙГ  
УЯЛАСАН  
НИЙВЭЙГ

ДАН ДАН  
ДАВТСАН  
ТОГ ТОГ  
ТОГШСОН  
ИРЭЭДҮЙ  
ХОЙЧИЙН  
ЖИГУУРТ  
ХУЛГИЙГ  
ДАН ДАН  
ДАВТНА  
ТОГ ТОГ  
ТОГШИНО.



САНСРЫН ХӨЛӨГ

ГАН  
БОЛД  
ХОШУУ  
ДЭЭШЭЭ  
ГАГЦХҮҮ  
ОДОД УРУУ  
ТЭМҮҮЛЭЭД  
ГАРИГ ТИЙШ  
ДҮҮЛЛЭЭ ШҮҮ  
ГАЙХАМШИГТАЙ  
САНСРЫН ХӨЛӨГ  
ГАРААНААС ГАРЧ  
ЯГ ХӨӨРЛӨӨ ШҮҮ  
АЛИВ СУУГААРАЙ  
АНГАРАГ НИСЛЭЭ  
ТЭНДЭЭС ЦААШАА  
ДОЛООН БУРХАНД  
ТЭГЭЭД УДАА НЬ  
ҮҮРИЙН ЦОЛМОНД  
ХАР ШАР ЦАГААН  
ХАМТ АЯЛНА ШҮҮ  
АНХАЛЖ ГАГАРИН  
САНСАРТ ЗАССАН  
АЛДАРТ ҮЙЛСИЙН  
БАТ БӨХ ЗАМААР  
ОРЧЛОНГИЙН ҮРС  
ОЛУУЛАА НИСЛЭЭ  
ОДОН ГАРИГ УРУУ  
ОДООХОН НИСЛЭЭ

НЭГ ЦОО ШИНЭ ГАРИГ НЭГ  
ХОЁР УГТАН МЭНДЭЛНЭ ХОЁР  
ГУРАВ ШИВ ШИНЭ ТАНИЛ ГУРАВ  
НИСЛЭЭ УУЛЗАН ЗОЛГОНО НИСЛЭЭ  
НИСЛЭЭ САНСРЫН АЯНДАА НИСЛЭЭ  
ЦЭНХЭР ТАВТАЙ ЯВААРАЙ ЦЭНХЭР  
ЗАМДАА САЙНЫ ЕРӨӨЛӨӨР ЗАМДАА  
ГАРЛАА БАЯРТАЙ УУЛЗАЯ ГАРЛАА  
ГАРЛАА ГАРЛАА  
ГУРАВ ГУРАВ  
ХОЁР ХОЁР  
НЭГ НЭГ







Жамбын ДАНЦОНДОГ

**ӨРГӨӨ**

Ропалих шүлгүүд

*Бага насны хүүхдэд*

(Гуравдахь хэвлэл)



Далхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй  
"Хөдөөгийн Боловсролыг дэмжих  
(READ) төсөл"-ийн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.

*Хянал тогтоолдуулсан Ө.Мөнхмуза  
Зурвалч Д. ОВДОГМИД, М. СОЛОНГО  
Хөдөөгийн элчиг Э. БАВРАМГИЙ*

**интерпресс**

Интерпресс хэвлэлийн компанид хэвлэв.  
Улаанбаатар 2007

